



**ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ,
ТҮҮНИЙ ҮР ДҮН:**

- Стратегийн зорилт, тэргүүлэх чиглэлийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн шаардалагатай төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, сунгах захиалах авах бүртгүүлэх боломжийг бүрдүүлэн мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /EMongolia/-д улсын бүртгэлийн 86 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн бусад үйлчилгээг иргэд цахимаар авах боломж бүрдсэн байна. Дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг Англи хэл дээр авах боломжийг бүрдүүлж Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/-д сервис гаргаж өгсөн. Байгууллагын үйл ажиллагааны асуудлаар төрийн болон бусад байгууллагатай мэдээлэл солилцох ХУР систем болон дундын мэдээллийн сангийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Шивээговь сумаандаа төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй түргэн шуурхай хүргэх зорилгоор 24/7 цахим үйлчилгээг үзүүлээд байгаа юм.